

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	30
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	31
ДӨРӨВ .НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	36
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	39
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	42
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	43
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ	43

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 28. Төслийн ерөнхий мэдээлэл	3
Хүснэгт 29. Тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол	5
Хүснэгт 30. Ил уурхайн календарь төлөвлөгөө	12
Хүснэгт 31. Ашиглалтын системийн үндсэн технологийн процессуудыг	14
Хүснэгт 32. Уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд	15
Хүснэгт 33. Угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлт	16
Хүснэгт 34. Баяжуулах ширээний техникийн үзүүлэлт	17
Хүснэгт 35. Эргэлтийн усны насосын техникийн үзүүлэлт	17
Хүснэгт 36. Эргэлтийн усны насосын техникийн дэд үзүүлэлт	17
Хүснэгт 37. Худгийн координат	19
Хүснэгт 38. Ахуйн ундны усны тооцоо	19
Хүснэгт 39. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ	20
Хүснэгт 40. Технологийн ус хэрэглээ	21
Хүснэгт 41. Туул голын урсацын харуулын мэдээ	21
Хүснэгт 42. Туул голын олон жилийн урсацын анализ 2010-2020 он	22
Хүснэгт 43. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт	23
Хүснэгт 44. JANGSU JULANG DG46-200x4 маркийн насосны техникийн үзүүлэлт	23
Хүснэгт 45. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ	24
Хүснэгт 46. Нийт усны тооцоо	24

Хүснэгт 47. RO – 2000L/H маркын ус шүүгчийн техникийн үзүүлэлт	25
Хүснэгт 48. Ус ашиглах болон хаяж, зайлуулах, зөвшөөрлүүд.....	26
Хүснэгт 26. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	31

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ


Зураг 14. Төслийн талбайн байршлын зураг.....	8
Зураг 15. Төслийн талбайн байршлын зураг.....	9
Зураг 16. Төслийн харагдах байдал /DJI Mavic 4 Pro дроны зураг/.....	10
Зураг 17. Төслийн нөхөн сэргээлт хийсэн талбайн харагдах байдал /DJI Mavic 4 Pro дроны зураг/	11
Зураг 18. Ил уурхайн календарь төлөвлөгөө	12
Зураг 19. Уурхайн 2 дах жилийн эцсийн байдал.....	13
Зураг 20. Элс угаан баяжуулах технологийн схем	16
Зураг 21. Уурхайн цахилгаан хангамжийн схем	18
Зураг 22. Худгийн байршил.....	19
Зураг 23. Голоос ус татах хэсэг	22
Зураг 22. Хогийн савны төрөл.....	38

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	“Оюут цахир уул” ХХК
1.2	Регистрийн дугаар:	РД: 6637833
1.3	Улсын бүртгэлийн дугаар:	УБД: 9011822879
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, 16, 17 тоот Утас: 91192110
1.5	Тусгай зөвшөөрөл:	АМГТХЭГ-ын даргын 2025 оны 05-р сарын 02-ны өдрийн 268 дугаартай шийдвэрээр “Оюут цахир уул” ХХК өөрийн нэр дээр шилжүүлэн авсан байна.
1.6	Нөөц хүлээн авсан тушаал, тэмдэглэл дүгнэлт	Үндэсний геологийн албаны 2026 оны 04 сарын 01-ны өдрийн Н-28 тоот бүхий нөөц бүртгэхтухай хүлээн авсан тушаал Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны АМГТГ-ын нөөц тодотгол хүлээн авсан 2026 оны 02 сарын 26-ны өдрийн ХХ-01-05 тоот тэмдэглэл дүгнэлт
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төсөл
2.2	Төслийн зорилго	“Оюут цахир уул” ХХК нь Монгол Улсын 9011822879 тоот улсын бүртгэлийн дугаартай бөгөөд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Үүнд Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын төлбөрийн тухай, Татварын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Агаарын тухай, Усны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай, Химийн хорт бодисоос хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Галын аюулгүй байдлын тухай, Амьтны аймгийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Аюултай хог хаягдлын импорт, Экспортын тухай, Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай, Компанийн тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай гэх зэрэг хуулийг мөрдлөг болгон ажиллана.


2.3	Төслийн талбайн байршил	Дунд Галт нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт хамаарах бөгөөд Туул голын зүүн эрэгт байрлана. Тус талбай нь Улаанбаатар хотоос ойролцоогоор 240 км, Булган аймгаас баруун урд (БУ) чиглэлд 100 км, Эрдэнэт хотоос зүүн урд (ЗУ) чиглэлд 130 км, Заамар сумаас зүүн урд (ЗУ) чиглэлд 40 орчим км, Заамарын уурхайн Өгөөмөр тосгоноос зүүн хойд (ЗХ) чиглэлд 12 орчим км зайд оршино. Ордын цэгийн солбицол нь уртраг 104°20'29.84" Е, өргөрөг 48°14'03.23" N байна. 
2.4	Төслийн хүчин чадал	Уурхайн хүчин чадал нь 110.0-144.9 мян.м3 элс олборлох бөгөөд уул техникийн нөхцөлөөс хамааран ашиглалтын 2 жилд элс, хөрсний хэмжээ жигд бус байна. Дунд галтайн алтны шороон орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд жилд 6 сарын хугацаатай ажиллана. Уулын бэлтгэл ажил, уурхайн нээлт, хаалт зэрэг хугацааг оруулж, алт олборлох хамгийн боломжтой бодит хувилбар нь энэ ордыг 2 жилд олборлож дуусгах юм. 145.0 мян.м3 Алт агуулсан элс олборлоно.
2.6	Төслийн хог хаягдал	Хатуу хог хаягдал: Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 53.32 кг, жилд 8104.64 кг орчим хаягдал гарах бөгөөд харъяа сумын холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэхээр төлөвлөсөн байна. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.

Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт

Бусад хог хаягдал: Түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд

Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн/ өдрийн гэрэл, цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.

Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай



Шингэн хог хаягдал:

Вахт системээр 62 хүн ажиллана гэж үзвэл хоногт 6.3 м3, жилд улирлын чанартай ажиллах ба 152 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх ахуйн усны хэмжээ 1413.6 м3/жил болно.

1.2 Төслийн байршил

Дунд Галт нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Заамар сумын нутагт хамаарах бөгөөд Туул голын зүүн эрэгт байрлана. Тус талбай нь Улаанбаатар хотоос ойролцоогоор 240 км, Булган аймгаас баруун урд (БУ) чиглэлд 100 км, Эрдэнэт хотоос зүүн урд (ЗУ) чиглэлд 130 км, Заамар сумаас зүүн урд (ЗУ) чиглэлд 40 орчим км, Заамарын уурхайн Өгөөмөр тосгоноос зүүн хойд (ЗХ) чиглэлд 12 орчим км зайд оршино.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол


№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	104	21	0.92	48	13	37.82
2	104	21	0.94	48	14	29.91

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	104	21	0.3	48	14	29.67
4	104	20	56.61	48	14	28.55
5	104	20	53.77	48	14	27.46
6	104	20	51.12	48	14	26.37
7	104	20	47.98	48	14	24.91
8	104	20	45.55	48	14	23.86
9	104	20	41.93	48	14	20.46
10	104	20	37.38	48	14	21.64
11	104	20	35.92	48	14	21.4
12	104	20	35.15	48	14	21.24
13	104	20	25.11	48	14	9.84
14	104	20	17.82	48	14	11.9
15	104	20	17.48	48	14	11.9
16	104	20	17.32	48	14	11.82
17	104	20	15.01	48	14	10.58
18	104	20	13.47	48	14	9.61
19	104	20	13.01	48	14	9.27
20	104	20	13.01	48	14	9.12
21	104	20	12.81	48	14	9.12
22	104	20	11.21	48	14	7.95
23	104	20	9.81	48	14	7.01
24	104	20	7.02	48	14	4.07
25	104	19	50.81	48	13	56.35
26	104	19	50.54	48	13	53.41
27	104	19	50.33	48	13	52.06
28	104	19	50.14	48	13	51.18
29	104	19	49.7	48	13	49.71
30	104	19	49.03	48	13	48.13


“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

31	104	19	48.65	48	13	47.51
32	104	19	48.17	48	13	46.88
33	104	19	47.14	48	13	45.84
34	104	19	45.91	48	13	44.91
35	104	19	44.22	48	13	43.99
36	104	19	42.55	48	13	43.3
37	104	19	40.12	48	13	42.54
38	104	19	39.21	48	13	42.16
39	104	19	34.8	48	13	39.76
40	104	19	32.85	48	13	38.81
41	104	19	31.92	48	13	38.39
42	104	19	31.92	48	13	37.82



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 3. Төслийн харагдах байдал /DJI Mavic 4 Pro дроны зураг/

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 4. Төслийн нөхөн сэргээлт хийсэн талбайн харагдах байдал /DJI Mavic 4 Pro дроны зураг/

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


1.3 Уурхайн хүчин чадал, тоо хэмжээ

Дунд галтайн алтны шороон ордыг ил уурхайн аргаар 2 жил ашиглана.

Уурхайн хүчин чадал нь 110.0-144.9 мян. м3 элс олборлох бөгөөд уул техникийн нөхцөлөөс хамааран ашиглалтын 2 жилд элс, хөрсний хэмжээ жигд бус байна. Дунд галтайн алтны шороон орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд жилд 6 сарын хугацаатай ажиллана.


Хүснэгт 3. Ил уурхайн календарь төлөвлөгөө

Үзүүлэлт	Хэмжих нэгж	I жил	II жил	Нийт
Элс олборлолт	мян.м3	109.96	144.92	254.88
Дундаж агуулга	мг/м3	197	134	161
Металл, химийн цэвэр	кг	21.63	19.46	41.09
Хөрс хуулалт	мян.м3	372.5	370.1	742.60
Уулын цул	мян.м3	482.4	515.0	997.48
Хөрс хуулалтын коэффициент	м3/м3	3.4	2.6	2.9



Зураг 5. Ил уурхайн календарь төлөвлөгөө

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 6. Уурхайн 2 дах жилийн эцсийн байдал

1.4 Уурхайн ажиллах горим

Ил уурхайн ажиллах горим нь улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, хамаарах бөгөөд уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, жилийн хүчин чадал зэргээс ихээхэн шалтгаална. Уурхай нь жил бүрийн 5-р сарын 1-ээс эхлэн 10-р сарын 30 хүртэл 6 сарын хугацаатай ажиллана гэж тооцоолсон.

№	Уурхайн ажиллах горим	Үзүүлэлт	
1	Хуанлийн хоног	365	өдөр
2	Жилд ажиллах хоног	180	өдөр
3	Баяр ёслол	6	өдөр
4	Цаг агаарын хүнд нөхцөл тооцсон хоног	4	өдөр
5	Засвар үйлчилгээ, бэлтгэл ажил	20	өдөр
6	Ажлын хоног	152	өдөр
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	12	цаг
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	2	ээлж
Ээлжийн цаг ашиглалт			
9	Ээлж хүлээж авах	15	мин

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

10	Өглөөний цай	30	мин
11	Өдрийн цай	30	мин
12	Оройн цай	30	мин
13	Ээлж хүлээлгэн өгөх	15	мин
14	Ээлжийн цэвэр ажиллах цаг	10	цаг
15	Хоногт цэвэр ажиллах цаг	20	цаг
16	Ээлжийн цаг ашиглалт	83.3	%

1.5. Ашиглалтын систем

Ордыг ил уурхайн аргаар ашиглах ба уурхайн хөрс хуулалтын ажлыг Авто тээвэр бүхий дотоод овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын технологиор гүйцэтгэнэ. Ордын элсний давхаргын сунаж тогтсон байдал нь дотоод овоолго үүсгэх, нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг багасгах хөрсний тээвэрлэлтийн зайг бага байлгах давуу талуудыг үүсгэнэ.

Хөрс хуулалтын ажлыг дотоод овоолго хийх орон зай бий болох хүртэл хуулсан хөрсийг гадаад овоолгод хийх ба энэхүү орон зай бий болсон үед ордын ашиглалтыг дуустал дотоод овоолго хийнэ.

Элс олборлолтын ажлыг авто тээвэртэй ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Олборлосон элсээ экскаватор болон автосамосвалын тусламжтай угаах тоног төхөөрөмжийн ойролцоо элсний нөөцийн овоолгод байршуулан угаах төхөөрөмжийн хаягдлыг хоосон орон зайд хийнэ.

Ордын уул техник, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлийг үндэслэн ил аргаар, тээвэртэй ашиглалтын системийг сонгов.

Хүснэгт 4. Ашиглалтын системийн үндсэн технологийн процессуудыг

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй, ашиглалтын технологи	Хөрс, хуулалт	Ухаж, ачих ажил
		Тээвэрлэх
		Гадаад ба дотоод овоолго үүсгэх
	Олборлолт	Ухаж, ачих ажил
		Тээвэрлэх (Угаах үйлдвэр)

1.6. Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд

Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглаж байгаа техникүүдийг үргэлжлүүлэн ашиглахаар тооцсон. Уурхайн хөрс хуулалтын ажилд Hitachi ZX670 маркийн экскаватор 2 ширхэг, элс олборлолтын ажилд Hitachi ZX330H маркийн экскаватор 1 ширхэг, хөрс тээвэрлэлтийн ажилд Howo ZZ3257N маркийн 25тн даацтай автосамосвал

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5 ширхэг, элс тээвэрт Howo ZZ3257N маркийн 25тн даацтай автосмасвал 4 ширхгийг тус тус ашиглана. Ашиглалтын нийт хугацаанд 742.6 мян. м3 хөрс хуулж 254.88 мян.м3 элс олборлоно. Шимт хөрс хуулалт, ул тааз цэвэрлэгээ болон туслах ажилд SHANTUI-SD32 маркийн бульдозер-1, скрубер тэжээлээр хангах болон туслах LIUGONG-855H маркийн 3м3 утгуурын багтаамжтай утгуурт ачигч 1 ширхгийг тус тус ашиглана.

Хүснэгт 5. Уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн марк	Тоо, ш	Ажиллах зориулалт
1	Экскаватор	Hitachi ZX330H	1	Элс олборлолт
2		Hitachi ZX670	2	Хөрс хуулалт
3	Автосамосвал	Howo ZZ3257N	4	Элс дотоод тээвэр
4		Howo ZZ3257N	5	Хөрс дотоод тээвэр
5	Бульдозер	SHANTUI- SD32	1	Овоолго
6	Утгуурт ачигч	LIUGONG-855H	1	Баяжуулах
7	Грейдер	XCMG GR180	1	Технологийн ажил

1.7. Элс угаан баяжуулах технологи

Алтны шороон ордын NZMS Screen 60 угаах төхөөрөмжийн хаягдал элс (эфель), болон хаягдал чулуу (галь) -иас авсан дээж тус бүрийг боловсруулан баяжмалыг минералогийн шинжилгээнд өгч гарсан алтыг тооцож дүгнэхэд

NZMS Screen 60 угаах төхөөрөмжийн алт авалт 94.05% байна.

Хоригт цоргоны хаягдалд металлын алдагдлын хэмжээ 5.58%

Хаягдал чулуу дахь металлын алдагдлын хэмжээ 0.38% тус тус байна.

Хаягдалд алдагдаж байгаа алт нь 0.03*0.06 мм-ээс 0.3*0.42мм-ийн хэмжээтэй, хагас болон сайн мөлгөржсөн, хавтгай, гонзгой, зөв бус, бөөрөнхий, хэлбэртэй мөхлөгүүд байна.

Элс угаан баяжуулах технологи:

Төсөл хэрэгжүүлэгч “Оюут цахир уул” ХХК нь алтны шороон ордын элсийг олборлон баяжуулах, нөхөн сэргээх тал дээр өмнө ажиллаж байсан туршлагатай бөгөөд ордыг ашиглахад тоног төхөөрөмж, ажиллах хүчний хувьд бүрэн бололцоотой юм.

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчний тоног төхөөрөмжийг ашиглана. Шинэ-зеланд улсын ангилан ялгах болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг NZMS Screen-60 гүйцээн баяжуулалтанд баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихыг ялгаж авна. Угаах төхөөрөмжөөс

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ялгасан шлихын баяжмалыг гүйцээн боловсруулах цехэд боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулах ба дараа нь соронзонгоор хар шлихийг ялгаж цахилгаан зуухан дээр хатааж, тороор шигшин ангилж, ангилал тус бүрийг үлээн ялгана¹.



Зураг 7. Элс угаан баяжуулах технологийн схем

Элс угаан баяжуулах хэсэгт ажиллах тоног төхөөрөмж:

Төсөл хэрэгжүүлэгч нь Шинэ-Зеланд улсын металл авалт өндөртэй угаах төхөөрөмж болох NZMS Screen-60, СКО-0.5 маркийн тоног төхөөрөмжүүдийг ашигладаг. Эдгээр баяжуулах тоног төхөөрөмжийг төсөл эхлэхэд сонгохдоо ордын ашиглалтын нөхцөл, хүчин чадал, ус хангамжийн эх үүсвэр болон усны ундаргын хэмжээ, хаягдал хураах нөхцөл, хүдрийн мөхлөгийн хэмжээ зэргийг үндэслэн сонгон ашиглаж байна.

Захиалагч компанийн хувьд тус районд өмнө шороон ордын олборлолт, боловсруулалт хийж байсан бөгөөд компанид одоо байгаа тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг тооцон үргэлжлүүлэн ашиглахаар төсөлд тусгасан.

Ордын элсэнд агуулагдах шаврын агуулга, элсний угаагдах шинж чанараас хамааран угаах тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлын 60-70%-д ажилладаг байна. Иймд Screen-60 маркийн элс угаах төхөөрөмжийн хүчин чадлыг 30м³/цаг байхаар тоног төхөөрөмжийн тооцоог хийсэн.

Хүснэгт 6. Угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	-	Screen-60	
2	Хүчин чадал	м ³ /цаг	30	

¹ ТЭЗҮ, 47-р хуудас

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Бункерийн хэмжээ	L:W:H, м	8.5*2.0*3.8	
4	Торны нүхний хэмжээ	мм	13.5	
5	Ширхэглэлийн хэмжээ	мм	100	
6	Моторын марк	MWMD229-3		
7	Суурилагдсан чадал	кВт	22	
8	Хэрэглэгдэх тоо	ширхэг	1	

Хүснэгт 7.Баяжуулах ширээний техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк		СКО-0.5	
2	Тунах талбай	м2	6.8	
3	Ширээний урт	м	4.45	
4	Ширээний өргөн	м	1.55	
5	Хүчин чадал	тн/цаг	0.8-1.5	
6	Ширээний далайц	мм	16-22	
7	Суурилагдсан чадал	кВт	0.5	
8	Хэрэглэгдэх тоо	ширхэг	1	

Хүснэгт 8. Эргэлтийн усны насосын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	К-150-125-400		
2	Хүчин чадал	м3цаг	240	
3	Ус шахах өндөр	м	46	
4	Моторын эргэлт	эрг/мин	1450	
5	Суурилагдсан чадал	кВт	45	
6	Нийт жин	кг	150	
7	Хэрэглэгдэх тоо	ширхэг	1	

Хүснэгт 9. Эргэлтийн усны насосын техникийн дэд үзүүлэлт

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	WQG-100-35-18.5		
2	Хүчин чадал	мЗцаг	100	
3	Ус шахах өндөр	м	35	
4	Моторын эргэлт	эрг/мин	1450	
5	Суурилагдсан чадал	кВт	18.5	
6	Нийт жин	кг	320	
7	Хэрэглэгдэх тоо	ширхэг	1	

1.8 Дэд бүтэц

1.8.1 Цахилгаан хангамж

Дунд галтайн алтны шороон ордын уурхайн цахилгаан хангамжийг Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн 2025 оны 09 сарын 18-ны өдрийн 2025.09.0089 тоот техникийн нөхцөлийг гаргуулан уурхайн цахилгаан хангамжийг 35 кВ-ын Их алт цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №81-с салбар шугамын 19-р тулгуураас салбарлан шинээр 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/6 кВ-ын 630 кВА чадалтай дэд өртөө барьснаар шийдвэрлэсэн.

Дэд станц: Ил хуваарилах байгууламж 35кВ/6кВ-ын 630кВА,


Иж бүрдмэл дэд станц 6кВ/04кВ-ын 400кВА.

ЦДАШугам: 35кВ-ын агаарын шугамын трассын урт 0.01 км. 6кВ-ын кабель шугамын трассын урт 0.017 км.

6кВ-ын агаарын шугамын трассын урт 2.43 км цахилгаан эрчим хүчээр хангана.

Цахилгаан хэрэглэгчид

Ил уурхай байгуулах хэсэгт скруббер, эргэлтийн усны насос, засварын цех, контор, ажилчдын байр зэрэг цахилгаан хэрэглэгчтэй байх бөгөөд эдгээр нь 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдана.



Зураг 8. Уурхайн цахилгаан хангамжийн схем

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.8.2 Усан хангамж

1) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ

Уурхайн ажиллагсдын унд, ахуйн хэрэгцээний усыг тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойно байрлах, уурхайн тосгоны ойролцоо байдаг 4.2 л/сек ундаргатай гүний худгаас хангана². “Уулс Заамар” ХХК-тай байгуулсан худаг ашиглах гэрээтэй.

Хүснэгт 10. Худгийн координат

	Уртраг	Өргөрөг	Ундарга
Худаг	104°20'6.40"E	48°13'57.30"N	4.2 л/сек



Зураг 9. Худгийн байршил

Төслийн хүрээнд нийт 93 хүн ажиллах бөгөөд ВАХТ-ийн системээр нэг ээлжинд 62 хүн ажиллана³.

(* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц – 150л/хоног/хүн)

Хүснэгт 11. Ахуйн ундны усны тооцоо

Олборлолтын үе	Норм,	Хүний тоо,	Усны зарцуулалт
----------------	-------	------------	-----------------

2 ТЭЗҮ 63-р хуудас

3 ТЭЗҮ 100-р хуудас

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	л/хоног	ш	м3/хоног	Жилд ажиллах хоног	м3/жил
1-р жил	150л/ажилтан	62	9.3	180	1674.0
2-р жил	150л/ажилтан	62	9.3	180	1674.0

2) Зам талбайн усны хэрэглээ

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 7 долоо хоног тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоногдсон нэг усалгааны машин гүйцэтгэнэ.

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан ус хэрэглээний нормын дагуу 1 м2 зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол.

Уурхайн ашиглалтын хүрээнд зам харилцаанд өртөх 0.7 га /7000 м2/ байна4.

Хүснэгт 12. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд услах зам, м2	Норм, л	7 хоногт услах тоо	Жилд услах тоо	Ашиглах ус, м3/жил
1-р жил /180 хоног ажиллана/	7000.0	2.0	1	26	364.0
2-р жил /180 хоног ажиллана/	7000.0	2.0	1	26	364.0

3) Уурхайн усан хангамж

Тус ордын элс угаан баяжуулах усан хангамжийн хувьд хаягдлын сангаас 200-300 м-ийн зайд байрлах Туул голоос шаардлагатай цэвэр усны хэрэгцээг хангана.

Хаягдлын санд эргэлтийн усны систем ашиглан угаах төхөөрөмжийн хаягдалтай хамт хаягдсан усыг тунгааж эргүүлэн угаах төхөөрөмжүүдийг эргэлтийн усаар хангана. Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар хангаж, нуурын түвшинг тогтмол барьж байх шаардлагатай. Элс угаан баяжуулахад шаардлагатай усны 70-72%-ийг эргэлтийн усаар, 28-30%-ийг цэвэр усаар хангана5.

4 ТЭЗҮ 68-р хуудас

5 ТЭЗҮ 54-р хуудас

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОНХАЖ-ын сайдын 2015.07.30-ны А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын 2-р хавсралтанд алтны шороон ордын 1 м3 элсийг угаан баяжуулахад 4 м3 ус хэрэглэнэ гэж нормчилсон байна.

Хүснэгт 13. Технологийн ус хэрэглээ

Олборлолтын үе		
	1-р жил	2-р жил
Элс олборлолт мян.м3	109.96	144.92
Усны хэрэглээ мян.куб	439.84	579.68
70% нь эргэлтийн ус	307.89	405.78
30 % нь цэвэр ус	131.95	173.9

Технологийн нэмэлт усны хэрэглээнд жилд 131.95 – 173.9 мян.м3 ус ашиглана.

Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг.

Технологийн усан хангамжийн үйл ажиллагаа нь тунгаагуур бүхий усан сан-уст давхаргаас шүүрсэн ус хуримтлуулах усан сан –ус шахах насос –угаах төхөөрөмж гэсэн схемээр явагдана.

Төслийн талбайн зүүн хойд талаар 200м зайтай Туул гол урсана. Тус алтны шороон орд нь 45 кВт цэвэр усны DG46-200×4 маркийн насосоор цагт 30 м3 голын усыг цэвэр усны нуур луу 200 метр урт бүхий 100 мм-ийн хоолойгоор, 54 м-ийн напортой 50 кВт эргэлтийн усны ИН-260 маркийн насосоор цагт 80 м3 ус сэлбэж баяжуулахаар тооцов.

Тус туул голын урсац нь 2025 оны дундаж урсац 30.1 м3/сек байна. Энэ нь технологит шаардлагатай нэмэлт усанд хүрэлцээтэй юм. /Цаг уур орчны шинжилгээний газар Архив мэдээллийн сангийн хэлтсийн 2025.03.24/-ний өдрийн мэдээг хавсаргав.

Хүснэгт 14. Туул голын урсацын харуулын мэдээ

сар	Түвшин-Н, /см/	Өнгөрөлт Q /м³/с /
1	165	6.9
2	154	4.1
3	154	4.4
4	174	11.3
5	170	8.6
6	184	15.0
7	218	39.2
8	217	37.4
9	207	28.8
10	196	20.3
11	186	9.4
12	173	3.6

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


Туул голын олон жилийн урсацын анализ дата 2010-2025 он хүртэлх дундаж 22.48 м3/с болж байна. Мэдээлэл цуглуулсан эх үүсвэрүүдийг доор оруулав. 6

Хүснэгт 15. Туул голын олон жилийн урсацын анализ 2010-2020 он

Он	Жилийн дундаж урсацын хурд (м³/сек)
2010	24.5
2011	23.8
2012	22.9
2013	22.1
2014	21.5
2015	20.8
2016	20.2
2017	19.7
2018	19.1
2019	18.6
2020	18.0
2021	24.8
2022	19.2
2023	22.0
2024	32.5
2025	30.1

Туул голоос ус татах хэсэг

Тус алтны шороон орд нь 45 кВт цэвэр усны DG46-200×4маркийн насосоор цагт 30 м3 голын усыг цэвэр усны нуур луу 200 метр урт бүхий 100 мм-ийн хоолойгоор 54м-ийн напортой 50 кВт эргэлтийн усны ИН-260 маркийн насосоор цагт 80 м3 ус сэлбэж баяжуулахаар тооцов.



Зураг 10. Голоос ус татах хэсэг

“Оюут цахир уул” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-009305 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дунд галтайн алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Усан хангамжийн технологи

Усан хангамжийн тоног төхөөрөмж Угаан баяжуулах хэсгийн усан хангамжийн хэсэгт технологийн шаардлагатай ус болон эргэлтийн ус татах насосууд ашиглагдана.

Хүснэгт 16. Эргэлтийн усны насосны техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Тоон утга	
1	Тоног төхөөрөмжийн марк	ИН200-150-400	
2	Хүчин чадал, м³/цаг	260	
3	Ус шахах өндөр, м	55	
4	Моторын эргэлт, эрг/мин	1450	
5	Цахилгаан зарцуулалт, кВт	30	
6	Хэрэглэгдэх тоо, ширхэг	1	

Хүснэгт 17. JANGSU JULANG DG46-200x4 маркийн насосны техникийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Хүчин чадал	м³/цаг	46
2	Эргэлтийн хурд	эрг/мин	2900
3	Напор	м	200
4	Тооцооны чадал	кВт	45
5	Цэвэр жин	кг	285

4) Биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ

Уурхайн олборлолтод өртөх 14.9 га, хөрсний гадаад овоолгод өртөх 1.7 га, шимт хөрсний овоолгод өртөх 0.9 га, зам харилцаанд өртөх 0.7 га, ШТС 0.06 га, уурхайн барилга байгууламж өртөх 0.9 га, баяжуулах цехийн талбайд өртөх 2.0 га, нийт 21.0 га талбай үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааран шууд эвдэгдэнэ.7

Төслийн ил уурхайн 2 жилийн хугацаанд нийт 21 га (210000.0 м²) талбай нөлөөлөлд өртөх ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын 2 дахь жилээс эхлэн хийх юм.

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м³ нормоор услахаар тооцлоо.

